



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19 № 73

танай _____ ны № _____ т

**БУГАТ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Ж.СЭРГЭЛЭН ТАНАА**

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар нийт 26.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 26.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр өвч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЭНХЦООДОЛ

632502084



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Булган аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч : Ж.Энхцоодол Утас: 70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com Ахлах Аудитор: Б.Нарантуяа Утас: 99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19 № 62

танай _____ ны № _____ т

**БУГАТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ж.СЭРГЭЛЭН
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бугат ЭМТөв нь 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 749,775,3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 775,003,3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Сумын засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ний А/01 тоот захирамжаар 24 хүний бүтэц, орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн. 2024 онд 21 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Тайланд онд 47,663.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч нийт 1,409,319.1 мянган төгрөгийн хөрөнгөтэй болсон байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ   Ж.ЭНХЦООДОЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	131,127,153.55	162,767,064.620
33	АВЛАГА	23,985,022.00	67,336,988.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	62,370	-
33101	НДШ-ийн авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	16,596,302.00	67,336,988.68
33510	Байгууллагаас авах авлага	7,326,350.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	66,688,540.56	80,204,518.78
351	Түүхий эд материал	32,615,448.01	37,763,241.23
3513	Эм боох материал	32,615,448.01	37,763,241.23
354	Хангамжийн материал	34,073,092.55	42,441,277.55
3541	Бичиг хэргийн материал	512,800.00	512,800.00
3542	Аж ахуйн материал	31,295,762.55	40,890,962.55
3546	Хүнсний материал	2,264,530.00	1,037,515.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	712,068,413.43	1,185,722,832.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	712,068,413.43	1,185,722,832.55
392	Биет хөрөнгө	695,346,538.43	1,169,338,457.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	566,800,272.53	864,700,272.53
39202	Хуримтлагдсан элэгдэл-Барилга байгууламж	(75,527,905.20)	(89,983,486.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	72,072,000.00	183,952,947.50
39204	Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл	(43,604,499.79)	(51,380,833.01)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	184,038,343.91	274,791,837.75
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(45,183,886.60)	(66,170,310.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,513,945.40	46,575,905.40
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(12,487,967.47)	(10,331,969.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,682,328.00	20,545,328.00
39215	Хуримтлагдсан элэгдэл-Бусад үндсэн хөрөнгө	(2,458,917.26)	(3,864,059.04)
39217	Ном	502,824.91	502,824.91
393	Биет бус хөрөнгө	16,721,875.00	16,384,375.00
39301	Программ хангамж	1,950,000.00	1,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл-Программ хангамж	(1,528,125.00)	(1,865,625.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,300,000.00	16,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	843,195,566.98	1,348,489,896.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	843,195,566.98	1,347,486,042.55
51	Засгийн газрын хувь оролцоо	843,195,566.98	1,347,486,042.25
512	Хуримтлагдсан үр дүн	110,469,546.79	604,001,640.06
51210	Өмнөх үеийн үр дүн	110,469,546.79	110,469,546.79
51220	Тайлант үеийн үр дүн		493,532,093.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	843,195,566.98	1,348,489,896.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	601,967,477.95	1,347,452,687.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,909,936.08	488,172,432.21
120	Нийтлэг татварын бус орлого	47,909,936.08	488,172,432.21
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,255,584.00	256,860.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,654,352.08	487,915,572.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,057,541.87	859,280,255.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	71,255,700.00	67,055,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	786,506.00	30,240,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,255,700.00	71,255,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,255,700.00	71,255,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	673,859,109.03	853,920,594.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,859,109.03	853,920,594.51
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,051,097.74	853,920,594.51
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	318,286,412.14	538,681,623.64
210101	Үндсэн цалин	215,840,260.79	311,914,460.00
210102	Нэмэгдэл	80,692,941.07	175,867,511.64
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	3,241,000.00	11,575,000.00
210104	Урамшуулал	18,512,210.28	39,324,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,808,643.75	49,348,411.71
210201	Тэтгэврийн даатгал	23,665,537.58	35,682,107.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,763,449.99	3,950,161.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,475,851.56	2,482,523.22
210204	Ажилгүйдлийн даатгал	445,835.85	1,536,943.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,457,968.77	5,696,676.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,047,688.71	65,405,174.50
210301	Гэрэл, цахилгаан	4,291,992.71	3,992,716.47
210302	Түлш халаалт	59,755,696.00	61,412,458.03
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,964,600.00	20,520,830.00
210401	Бичиг хэрэг	2,072,750.00	2,353,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,011,800.00	12,061,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,291,500.00	1,835,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,381,550.00	3,239,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,207,000.00	1,031,500.00
2105	Нормативт зардал	146,706,723.56	84,785,815.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	129,390,138.56	75,028,603.63

210502	Хоол, хүнс	8,833,285.00	6,871,715.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,483,300.00	2,885,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,584,255.00	10,363,900.00
210604	Урсгал засвар	6,584,255.00	10,363,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,382,000.00	4,004,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,382,000.00	4,004,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,836,820.00	18,657,933.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	949,520.00	16,689,958.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,433,954.58	62,152,902.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,524,090.00	2,877,720.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	60,909,864.58	59,275,182.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,808,011.29	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-71,891,631.08	-493,532,093.27
5	НИЙТ ҮР ДҮН (V=III+IV)	-71,891,631.08	-493,532,093.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	540,921,201.87	816,831,028.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,461,239.87	808,539,568.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	786,506.00	30,240,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,255,700.00	67,055,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,255,700.00	67,055,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	531,363,499.20	790,842,863.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,363,499.20	790,842,863.14
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,555,487.91	790,842,863.14
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	318,321,077.91	538,619,253.64
210101	Үндсэн цалин	215,874,926.56	311,852,090.00
210102	Нэмэгдэл	80,692,941.07	175,867,511.64

210103	Унаа хоолны Хөнгөлөлт	3,241,000.00	11,575,000.00
210104	Урамшуулал	18,512,210.28	39,324,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,808,643.75	49,348,411.71
210201	Тэтгэврийн даатгал	23,665,537.58	35,682,107.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,763,449.99	3,950,161.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,475,851.56	2,482,823.22
210204	Ажилгүйдлийн даатгал	445,835.85	1,536,943.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,457,968.77	5,696,676.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,047,688.71	65,055,700.00
210301	Гэрэл, цахилгаан	4,291,992.71	3,643,241.97
210302	Түлш халаалт	59,755,696.00	61,412,458.03
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,847,200.00	21,513,630.00
210401	Бичиг хэрэг	3,218,850.00	2,353,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,011,800.00	12,061,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,291,500.00	1,835,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,422,850.00	3,020,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,902,200.00	2,243,000.00
2105	Нормативт зардал	69,739,122.54	74,491,663.98
210501	Эм,бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	57,382,806.48	66,851,843.98
210502	Хоол, хүнс	8,375,316.06	4,990,320.00
210503	Нормын хувцас,зөөлөн эдлэл	3,981,000.00	2,649,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,780,555.00	9,219,900.00
210604	Урсгал засвар	5,780,555.00	9,219,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,382,000.00	4,004,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,382,000.00	4,004,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,836,820.00	22,377,433.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	949,520.00	20,409,458.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,792,380.00	6,212,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,792,380.00	6,212,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,808,011.29	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,808,011.29	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,808,011.29	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)	9,557,702.67	25,988,165.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,179,900.00	51,216,200.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,179,900.00	51,216,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,179,900.00	51,216,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,179,900.00	51,216,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(19,179,900.00)	(51,216,200.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-9,622,197.33	-25,228,034.25
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	50,075,788.32	40,453,590.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,453,590.99	15,225,556.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	202... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	351,768,404.10	110,469,546.79	0.00	843,195,566.98
2	Нагтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ноогдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
10	202... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	351,768,404.10	110,469,546.79	0.00	843,195,566.98
11	202... оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00		0.00	0.00
12	Нагтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	10,758,382.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ноогдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	493,532,093.27	0.00	493,532,093.27
20	202... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,957,616.09	362,526,786.10	604,001,640.06	0.00	1,347,486,042.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	712,091,000.00	842,059,063.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,091,000.00	790,842,863.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	712,091,000.00	790,842,863.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,166,100.00	538,619,253.64
210101	Үндсэн цалин	267,564,000.00	311,852,090.00
210102	Нэмэгдэл	126,882,500.00	175,867,511.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,199,600.00	11,575,000.00
210104	Урамшуулал	38,520,000.00	39,324,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,283,300.00	49,348,411.71
210201	Тэтгэврийн даатгал	36,912,700.00	35,682,107.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,342,700.00	3,950,161.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,294,200.00	2,482,523.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,048,300.00	1,536,943.96
210205	Эрүүл мэндийн даатгал	8,685,400.00	5,696,676.21
2104	Хангамж, бараа материалын зардал	29,883,000.00	21,513,630.00
210401	Бичиг хэрэг	2,750,000.00	2,353,300.00
210402	Тээвэр, шатахуун	20,249,700.00	12,061,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,883,300.00	1,835,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	3,020,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	2,243,000.00
2105	Нормативт зардал	84,745,600.00	74,491,663.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	65,203,600.00	66,851,843.98
210502	Хоол, хүнс	13,042,000.00	4,990,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.00	2,649,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,877,300.00	9,129,900.00
210601	Багаж, техник хэрэгсэл	13,377,300.00	
210604	Урсгал засвар	3,500,000.00	9,219,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,382,000.00	4,004,000.00
210702	Дотоод албан томилолт	2,248,000.00	4,004,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	10,551,800.00	22,377,433.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,641,700.00	20,409,458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	60,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	3,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,299,600.00	842,825.81
210807	Газрын төлбөр	40,500.00	0.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	2,500,000.00	366,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,027,800.00	6,212,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,027,800.00	6,212,870.00
213	УРСГАЛ ЗАРДАЛ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,921,201.87	816,831,028.89
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,255,700.00	67,055,700.00
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		30,240,000.00
122005	Орон нутгийн төсвөөс	71,255,700.00	67,055,700.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь "Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах. Эрүүл мэндийн төвийн байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлага зохицуулалтаар хангах, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанар үр дүнг сайжруулах" зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Нэг иргэнд ноогдох санхүүжилт буюу улсын төсвөөс 448,2 мянган төгрөг, Үндсэн тусламж үйлчилгээ буюу гүйцэтгэлээр олсон орлого 263,0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл буюу өмнөх оны үр дүн 15,225.5 мянган төгрөг байна. Эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэд үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй жигд хүртээмжтэй хүргэх, ажилчдын нийгмийн баталгааг хангаж ажиллах чиг үүрэгтэй ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар, Булган аймгийн Засаг даргын 2020 оны А/24 тоот захирамжийг үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,639.9 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	23,985	67,336	43,351.9
Бараа материал	66,688.5	80,204.5	13,515.7
Үндсэн хөрөнгө	712,068.4	1,409,319.1	697,250.7
Нийт хөрөнгө	843,195.5	1,348,489.8	505,294.3
Өр төлбөр	0.00	1,003,854	1,003,854
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	843,195.5	1,347,486	504,290.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	843,195.5	1,348,489.8	505,294.3

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,347,452.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,347,452.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 711,210.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 775,311.6 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь урд оны үлдэгдлээс санхүүжсэнтэй холбоотой

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эмнэлэгийн тусламж үйлчилгээ	617,425.6	579,772.6	37,653.0	95%
2	80302-Нэг иргэнд ногдох нормативаар	346,740.7	319,941.2	26,799.5	90%
3	81603-Үндсэн үйл ажиллагаа	239,287.9	232,265.9	6,962.8	90%
4	83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	115,7	-	115,7	0%
5	83601-Нэмэлт Дээд шатны төсвөөс	240,0	240,0	0.00	100%
5	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	30,000.0	27,325.5	2,674.5	96%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган аймгийн Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн Бугат сумын ЭМТ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймгийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 853,920.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,280.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 64,044 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг алдаа дутагдал гаргахгүй маш сайн хэрэгжүүлж ажилласан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 171 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 165 мэдээг бүрэн мэдээлж, 1 хугацаа хоцорсон мэдээ байна. Хугацаа нь болоогүй 5 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, спидометрийн заалтыг дахин нягталж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягталж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон өрөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж.

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, нярвын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Албан шаардлага өгсөн.

Бараа материалын тайланд хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг шууд зарлагдсан 1547.3 мянган төгрөгийг буцаан орлогодох, данс хооронд шилжүүлж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг

үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Зөвлөмж.

Анхны ертгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ " хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж.

Цалингийн шөнийн илүү цагийг бодоходоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримталж ажиллаагүй. Зөвлөмж.

Санхүү байдлын тайлангийн авлагын дүн 708.2 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Залруулга.

Эд хариуцагч нь агуулахын бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан " Маягт заавар батлах тухай"-г стандартын дагуу хөтлөөгүй байна. Зөвлөмж.

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 5 нэр төрлийн нийт 26.8 мянган төгрөгийн эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Төлбөрийн акт тогтоох.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулгыг тухай бүрд нь хийж гүйцэтгэж хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	-	-	-	-	

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй болно.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ**

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 01/31 - 25452520

Булган сум

БҮА - 2025/079/НА - СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Бугат сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Эмийн үлдэгдлийг түүврийн аргаар тоолоход 26,885.0 (хорин зургаан мянга найман зуун наян таван) төгрөгөөр эм дутсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 26,885.0 (хорин зургаан мянга найман зуун наян таван) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бугат сумын ЭМТ-ийн дарга (Ж.Сэргэлэн), нягтлан бодогч (У.Энхзаяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  **Ж.ЭНХЦООДОЛ**

"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Г.МАЙЦЭЦЭГ

6317147
ТӨСВИЙН АУДИТ

632505060